

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
...-ний өдөр

Улаанбаатар сарын
хот

ХАЯГЖУУЛАЛТЫН ТУХАЙ /шинэчилсэн найруулга/ НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө болон бусад хаягийн объектод нэр, дугаар олгох, өөрчлөх, баталгаажуулах, хаягжуулах ажлыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Хаягжуулалтын тухай хууль тогтоомж

2.1.Хаягжуулалтын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Газрын тухай хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай, Хот байгуулалтын тухай, Геодези, зураг зүйн тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай, Авто замын тухай, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгох ба зөвхөн хаягжуулах зорилгоор хэрэглэнэ:

3.1.1.“хаягийн объект” гэж Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, өмчлөх, эзэмших, ашиглах эрх үүссэн газар, түүний дээрх болон доорх үл хөдлөх эд хөрөнгө, гудамж, зам, талбай, цэцэрлэгт хүрээлэн, хөшөө, соёл, дурсгал, аялал жуулчлалын байгууламж, байгууллага, аж ахуйн нэгж, нийтийн тээврийн буудлыг;

3.1.2.“хаяг” гэж хаягийн объектод өгсөн нэр, дугаар, байршлыг тодорхойлсон үсэг, тооны илэрхийллийг;

3.1.3.“хаягийн бүрдэл” гэж хаягийн объектын хаягийн мэдээллийн сангийн орон зайн мэдээлэл, нэр, дугаарыг;

3.1.4.”зам” гэж Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3.1.4-т заасныг;

3.1.5.”гудамж” гэж хот, суурин газрын эгнэсэн хашаа, барилга, байр, байшингийн хоорондох чөлөөг;

3.1.6.”талбай” гэж нийтийн эзэмшлийн тодорхой зааг бүхий талбар газрыг;

3.1.7.”хаягийн мэдээллийн сан” гэж газар зүйн мэдээллийн системд суурилсан хаягийн бүрдэл, мэдээллийг;

3.1.8.”хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн систем” Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 4.1.1-д заасныг;

3.1.9."хаягийн тэмдэг" гэж барилгын хана, хашаа болон зориулалтын тулгуур дээр байрлуулсан зураг, бичвэр бүхий мэдээллийг;

3.1.10."хаягийн дугаар" гэж хаягийн объектын байршлыг илэрхийлэх хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системээс олгосон дугаарыг;

3.1.11."хаягийн орон зайн мэдээлэл" гэж объектын байрлалтай шууд болон шууд бусаар холбогдох юмс үзэгдлийн тухай мэдээллийг;

3.1.12."хаягжуулах" гэж хаягийн объектыг нэрлэх, дугаарлах, хаягийн тэмдгийг стандартын дагуу үйлдвэрлэх, байршуулах, мэдээллийн систем үүсгэх, хөтлөх цогц үйл ажиллагаа;

3.1.13."шуудангийн нэгдсэн код" гэж Шуудангийн тухай хуулийн 3.1.10-д заасныг;

3.1.14."Шуудангийн нэгдсэн кодын бүс" гэж баг, хорооны заагийг;

3.1.15."Хаягийн зураг" гэж хаягийн объектын орон зайн мэдээлэл, нэр, дугаар бүхий зургийг.

4 дүгээр зүйл.Хаягжуулалтад баримтлах зарчим

4.1.Хаягжуулах үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

4.1.1.хаягжуулах үйл ажиллагаа нь газар зүйн мэдээллийн системд суурилсан байх;

4.1.2.засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарьт нийцсэн байх;

4.1.3.хаяг аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хот, тосгоны ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд туссан /төлөвлөгдсөн байх/ байх;

4.1.4.хаягжуулах ажил нэгдсэн арга зүйтэй байх;

4.1.5.хаягийн объектыг гудамж, замд харьяалуулсан байх;

4.1.6 Гудамж, зам, талбай бүр оноосон нэртэй байх;

4.1.7 сум, дүүрэгт гудамж, замын нэр давхардахгүй байх;

4.1.8 хаяг үнэн зөв, энгийн, ойлгомжтой байх;

4.1.9 кадастрын бүртгэлээр баталгаажсан байх;

4.1.10 хаягийн мэдээлэл хүртээмжтэй, нээлттэй байх.

4.2.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хаягийн талаар төрөөс явуулах нэгдсэн бодлогыг тодорхойлж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХАЯГИЙН ОБЪЕКТ, ХАЯГИЙН БҮРДЭЛ, ХАЯГИЙН ТЭМДЭГ

5 дугаар зүйл.Хаягийн объект

5.1. Дараах үл хөдлөх эд хөрөнгөд хаяг олгоно:

5.1.1.өмчлөх, эзэмших, ашиглах эрх үүссэн газар;

5.1.2.өмчлөх, эзэмших, ашиглах эрх үүссэн газрын дээрх болон доорх барилга, байгууламж;

5.1.3.газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх бүхий газар дээр баригдаж байгаа дуусаагүй барилга, байгууламж;

5.1.4.энэ хуулийн 5.1.1-5.1.3-т зааснаас бусад талбай, цэцэрлэгт хүрээлэн, хөшөө, соёл, дурсгал, аялал жуулчлалын байгууламж, байгууллага, аж ахуйн нэгж, нийтийн тээврийн хэрэгслийн буудал болон хаягжуулах, нэрлэх, нэрэмжит болгох, дугаарлах шаардлагатай гэж үзсэн объект.

6 дугаар зүйл.Хаягийн бүрдэл, бичвэр

6.1.Хаягийн бүрдэл, бичвэр нь хаягийн мэдээллийн санд заасан мэдээллээс бүрдэнэ.

6.2. Байршуулах хаягт байх мэдээллийг стандартаар зохицуулна.

7 дугаар зүйл.Хаягийн тэмдэг, хаягийн самбар

7.1.Хаягийн тэмдэг дараах төрөлтэй байна.

- 7.1.1.гудамж, замын;
- 7.1.2.үл хөдлөх эд хөрөнгийн;
- 7.1.3.барилга байгууламжийн;
- 7.1.4.байгууллага, аж ахуйн нэгжийн нэрийн;
- 7.1.5.барилга байгууламж доторх хаалганы;
- 7.1.6.объектын байрлал заасан;
- 7.1.7.нийтийн орон сууцны орц, хаалганы.

7.2.Хаягийн самбар дараах төрөлтэй байна.

- 7.2.1.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн;
- 7.2.2.хороолол, хотхоны;
- 7.2.3.талбайн;
- 7.2.4.байгууллага, аж ахуйн нэгжийн;
- 7.2.5.түүх, соёлын дурсгалт газрын.

7.3.Нийтийн зориулалттай объектод дүрсээр илэрхийлэгдэх хаягийн тэмдгийг хэрэглэж болно.

7.4.Хаягийн тэмдэгт тавигдах шаардлагыг энэ хуулийн 12.1-д заасан стандартаар зохицуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ХАЯГЖУУЛАХ АРГАЧЛАЛ

8 дугаар зүйл.Хаягжуулах дараалал

8.1.Хаягжуулах ажлыг дараах дарааллаар хийж гүйцэтгэнэ:

- 8.1.1.хаягийн зургийг бэлтгэх;
- 8.1.2.зөвлөлийн хурлаар гудамж, зам, талбайн хаягийн нэрийг нэрлэх, тогтоох;
- 8.1.3.гудамж, зам, талбайн нэрийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж батлуулах;
- 8.1.4.хаягийн зургийг газар зохион байгуулалтын төлөвлөлтийн мэдээллийн систем болон хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системд бүртгэх;
- 8.1.5.хаягийн тэмдгийг байршуулах.

9 дугаар зүйл.Хаягийн зураг бэлтгэх, гудамж, замыг тодорхойлох, нэрлэх

9.1.Хаягийн зургийг кадастрын зурагт суурилан бэлтгэнэ.

9.2.Хаягжуулах объект бүрд хамаарах гудамж, зам тэдгээрийн эхлэл, төгсгөлийг тодорхойлно.

9.3.Гудамж, зам, талбайг нэрлэх, өөрчлөх, нэрэмжит болгох санал боловсруулах үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн төлөөллөөс бүрдсэн 9-11

хүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус зөвлөлийг (цаашид “зөвлөл” гэх) аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын дэргэд байгуулна.

9.4.Хөшөө, соёл, түүхэн дурсгалт газрын нэрийг түүхэн уламжлалт нэрээр нь хаягийн зурагт тусгана.

9.5.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага гудамж, зам, талбайг нэрэмжит болгох асуудлыг санаачилж, энэ тухай хүсэлтээ сум, дүүрэг дэх нэрийн Зөвлөлд гаргаж болно. Гудамжийг нэрэмжит болгох журмыг аймаг, нийслэлээс тусгайлсан журмаар зохицуулна.

9.6.Аж ахуйн нэгж, аялал жуулчлалын байгууламжийн нэрийг тухайн эзэмшигч нь өгөх бөгөөд Монгол хэлний тухай хуулийн 4.1.1-д заасан төрийн албан ёсны хэлээр бичиж хаягийн зурагт тусгуулсан байна.

9.7 Хаягийн зурагт батлагдсан нэр болон үл хөдлөх эд хөрөнгийн дугаар, хаягжуулах объектыг бүрэн тусгаж гудамж, замын эхлэлээс түүнд хүрэх зайг бичнэ.

9.8.Гудамж, замын нэр сум, дүүрэг дотор давхардаагүй, унших, хэлэх, бичихэд хялбар, богино байна.

9.9.Гудамж, замын нэрэнд харьяа хамаарлын нөхцөл заах, товчилсон үг хэрэглэхгүй.

9.10.Гудамж, замыг нэрлэхдээ газар зүйн нэрийг үндэслэл болгоно.

9.11.Газар зохион байгуулалтын төлөвлөлтийн шатны нэгж талбарын хаягийн дугаарыг хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системээс автоматаар үүсгэнэ.

9.12.Гудамж, зам нэмэгдсэн тохиолдолд шинээр хаягжуулах нэрийг энэ хуулийн 13.5-д заасан сангаас өгнө.

9.13.Гудамж, зам нь түүнд хамаарах объектод хүрэх байдлаас хамааран эрэмбэтэй байна.

9.14.Гудамж, замын эхлэл, төгсгөл, чиглэл, төрөл, түүний тайлбар, эрэмбийг энэ хуулийн 10.7-д заасан аргачлалаар зохицуулна.

10 дугаар зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийг дугаарлах

10.1.Энэ хуулийн 5.1.1-5.1.3-д заасан үл хөдлөх эд хөрөнгө нь хаягийн дугаартай байна.

10.2.Хот, суурин газарт хаягийн дугаарыг харьяалагдах гудамж, замын эхлэл цэгээс тэгш, сондгойгоор дэс дараалуулан дугаарлана.

10.3.Гудамж, замын эхлэлээс зүүн талд байрлах объектыг сондгой тоогоор, баруун талд байрлах объектыг тэгш тоогоор дугаарлана.

10.4.Энэ хуулийн 10.2, 10.3-т зааснаас бусад тохиолдолд харьяалагдах гудамж, замын эхлэл цэгээс алслагдсан зайн хэмжээгээр хаягийн объектыг бүхэл тоогоор дэс дараалан дугаарлана.

10.5.Объектод хүрч очих хамгийн хялбар, дөт гудамж, замд тухайн объект харьяалагдана.

10.6.Энэ хуулийн 5.1.1-д заасан газар дээр нэг үл хөдлөх эд хөрөнгө байвал хаягийн дугаар нь газар болон газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн хувьд ижил байж болно.

10.7.Үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн дугаарлалт (хаягийн объектын дугаар, орц, гарц, давхар, өрөө)-ын аргачлалыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуульд нийцүүлэн боловсруулж, батална.

10.8.Дараах үл хөдлөх эд хөрөнгөд хаяг олгохгүй:

10.8.1.өмчлөх, эзэмших, ашиглах эрх үүсээгүй газар, түүн дээр баригдсан инженерийн барилга, байгууламж;

10.8.2.цэвэр, бохир ус, дулаан, хий, цахилгаан, эрчим хүч, харилцаа холбооны дамжуулах, түгээх инженерийн шугам сүлжээ;

10.8.3.түр хугацаагаар ашиглагдах барилга байгууламж.

11 дугаар зүйл. Шуудангийн нэгдсэн код

11.1.Хаяг бүр шуудангийн нэгдсэн кодтой байна.

11.2.Шуудангийн нэгдсэн кодын бүсийг баг, хорооны нутаг дэвсгэрийн заагаар тогтооно.

11.3.Баг, хорооны газар нутгийн заагт өөрчлөлт орсон тухай бүр шуудангийн нэгдсэн кодын бүс, код-д өөрчлөлт оруулж байх ба аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага мэдээллийг ажлын 5 өдөрт багтаан хаягийн мэдээллийн санд бүртгэж оруулна.

11.4.Шуудангийн нэгдсэн кодыг нэвтрүүлэх, хэрэглэхтэй холбоотой харилцааг Шуудангийн тухай хуулиар зохицуулна.

11.5.Шуудангийн нэгдсэн код давхардахгүй бөгөөд хүн амын өсөлт, суурьшлын нягтралтай уялдуулсан дугаарын нөөцтэй байна.

11.6.Шуудангийн нэгдсэн кодын бүсийг зүүн талаас баруун талруу, хойд талаас урд талруу өгсөх дарааллаар дугаарлана.

11.7.Энэ хуулийн 11.2-т заасан заагийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно.

11.8.Шуудангийн нэгдсэн кодтой холбоотой өөрчлөлт орсон тохиолдолд шуудангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ажлын 5 өдөрт багтаан газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлж, хаягийн мэдээллийн санд бүртгүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХАЯГЖУУЛАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

12 дугаар зүйл. Хаягжуулах ажлыг зохион байгуулах

12.1.Хаягийн тэмдэг, бичвэр, байршуулах үйл ажиллагааг стандартын дагуу зохицуулах ба стандартыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага боловсруулж, стандартын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

12.2.Сум, дүүргийн нутаг дэвсгэр дэх гудамж, зам, талбай, цэцэрлэгт хүрээлэн, нийтийн тээврийн хэрэгслийн буудал, хөшөө, соёл, түүхэн дурсгалт газрын хаяг, Засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрийн хил, газар нутгийн заагийн мэдээлэл бүхий хаягийн самбарыг байршуулж, хаягжуулах үйл ажиллагааг тухайн шатны Засаг дарга хариуцан зохион байгуулна.

12.3.Хаягжуулах үйл ажиллагааг эхний удаа улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийж, цаашид тухайн иргэн, хуулийн этгээд өөрийн хөрөнгөөр хаягжуулна..

12.4.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага төрийн үйлчилгээг бүрэн хариуцах, гамшиг ослын үед аюулгүй байдлыг хангах үүднээс хаягийн тэмдгийг стандартын дагуу байрлуулах үүрэг хүлээнэ.

12.5.Аялал жуулчлалын байгууламжийг тухайн иргэн, хуулийн этгээд хариуцан хаягжуулна.

12.6.Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа хөшөө, түүхэн дурсгалт газар, байгалийн өвөрмөц тогтоц бүхий газрыг аялал жуулчлалын зориулалтаар нэгдсэн бодлогоор хаягжуулах асуудлыг Байгаль орчин, ачлал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан зохион байгуулна.

12.7. Авто замын тухай хуулийн 17.2-17.4-т заасан авто зам эзэмшигч нь шинээр байгуулах болон өөрчлөх авто замын мэдээллийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тухай бүр хүргүүлнэ.

12.8.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага газар зохион байгуулалтын төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахад Авто замын тухай хуулийн 12.1.9-д заасны дагуу шинээр төлөвлөгдсөн болон өөрчлөгдөж байгаа авто замын мэдээллийг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авч тусган хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системд бүртгэнэ.

12.9.Энэ хуулийн 12.8-д заасан үйл ажиллагааг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дундын мэдээллийн сангаар дамжуулан хамтран гүйцэтгэнэ.

12.10.Стандартын шаардлага хангаагүй хаяг ашиглахыг хориглоно.

12.11.Хаягийн тэмдгийн бүрэн бүтэн байдалд сум, дүүргийн Засаг дарга хяналт тавина.

12.12.Хаягийн тэмдгийг байршуулагч болон үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч, эзэмшигч нь түүний бүрэн, бүтэн байдлыг хариуцна.

12.13.Үл хөдлөх эд хөрөнгө бүр хаягийн дугаар бүхий шуудангийн хайрцагтай байх бөгөөд өмчлөгч, ашиглагч шуудангийн хайрцаг байрлуулах үүрэг хүлээнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ ХАЯГИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН НЭГДСЭН СИСТЕМ

13 дугаар зүйл.Хаягийн мэдээллийн сангийн мэдээлэл

13.1.Хаягийн мэдээллийн санд энэ хуульд заасан хаягийн мэдээлэл болон бусад шаардлагатай мэдээллийг бүртгэнэ.

13.2.Хаягийн мэдээллийн сан дараах мэдээллээс бүрдэнэ:

13.2.1.газар зүйн нэр;

13.2.2.засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн нэр, хил, газар нутгийн зааг, түүнтэй холбоотой бусад мэдээлэл;

13.2.3.шуудангийн нэгдсэн кодын мэдээлэл;

13.2.4.хотхон, хорооллын нэр, түүнтэй холбоотой бусад мэдээлэл;

13.2.5.гудамж, замын нэр, төрөл, түүнтэй холбоотой бусад мэдээлэл;

13.2.6.үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн нэр, дугаар;

13.2.7.давхрын болон хаалганы дугаар

- 13.2.8. хаягийн тэмдэг, шуудангийн хайрцгийн байршлын мэдээлэл;
- 13.2.9. хаягийн нэрийн сан;
- 13.2.10. суурин утасны дугаар;
- 13.2.11. бусад.

13.3. Хаягийн мэдээллийн санд энэ хуулийн 13.2-т зааснаас гадна дараах орон зайн мэдээллийг бүртгэнэ:

- 13.3.1. газар зүйн нэрийн байршил;
- 13.3.2. засаг захиргаа нутаг, дэвсгэрийн нэгжийн нутаг дэвсгэрийн хил, газар нутгийн зааг;
- 13.3.3. шуудангийн нэгдсэн кодын зааг;
- 13.3.4. хотхон, хорооллын зааг;
- 13.3.5. гудамж, замын эхлэл, төгсгөл, чиглэл, эгнээ, төвийн утга, уулзвар, объект руу холбогдох цэгийн байршил;
- 13.3.6. үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн дугаар, түүний орц, гарц, төвийн цэг;
- 13.3.7. хаягийн тэмдэг, шуудангийн хайрцгийн байршлын мэдээлэл;
- 13.3.8. үл хөдлөх эд хөрөнгөрүү нэвтрэх нүүрэн талын замын төв цэг;
- 13.3.9. бусад.

13.4. Хаягийн мэдээллийн сан нь хаягийн нэрийн сантай байна.

13.5. Хаягийн нэрийн санг газар зүйн нэр, түүх, соёлын баримт, материалд үндэслэн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүрдүүлнэ.

13.6. Хаягийн нэрийн санд нэр үүсгэх, баяжуулах аргачлалыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

13.7. Хаягийн нэрийн сангийн нэрийг Монгол Улсын тусгаар тогтнол, хөгжил дэвшилд гарамгай гавьяа байгуулсан түүхэн хүмүүсийн нэр алдрыг мөнхлөх, түүх, соёл, түүхэн уламжлалыг хадгалах, түгээхэд чиглэсэн болон олон нийтээс санал авсан, утга агуулгын хувьд уялдаатай, энгийн, ойлгомжтой нэр, аюул, ослын үед хэлэхэд хялбар үгээр нэрлэнэ.

13.8. Хаягийн мэдээллийн санд замын эхлэл, төгсгөл, нэр, төрөл, бий болсон огноо, чиглэл, хурдын хязгаар болон бусад шаардлагатай мэдээллийг бүртгэнэ.

13.9. Энэ хуулийн 13.2, 13.3-т заасан хаягийн мэдээллийн сан, түүний мэдээлэл, мэдээллийг бүрдүүлэхтэй холбоотой нарийвчилсан журмыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

13.10. Улсын батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангуулах зориулалттай тусгай объектын байрлал, нэр, дугаар нийтэд хаалттай байна.

13.11. Хаягийн бүрдэл, мэдээллийг хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системээс хэвлэмэл болон тоон хэлбэрээр ашиглаж болно.

13.12. Улсын батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангуулах зориулалттай тусгай объектын хаягийн бүрдэл мэдээллийг нийтэд түгээхийг хориглоно.

13.13. Энэ хуулийн 13.1, 13.2-т заасан хаягийн орон зайн мэдээллийг кадастр, геодези, зураг зүйн тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллага тогтооно

14 дүгээр зүйл.Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг эрхлэх

14.1.Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн систем нь Газрын тухай хуулийн 16' дугаар зүйлд заасан газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн нэг бүрдэл байх ба Геодези, зураг зүйн тухай хуульд заасан байрлал, өндрийн нэгдсэн тогтолцоонд хийгдсэн цахим систем байна.

14.2.Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг улсын хэмжээнд газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хөтөлж, нэгдсэн удирдлага, хяналт, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

14.3.Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг улс, нийслэл, аймаг, дүүрэг, сумын хэмжээнд тогтмол хөтлөн явуулах бөгөөд хаягийн бүртгэл, мэдээлэл цуглуулах, өөрчлөх, баталгаажуулах болон хаягийн бүртгэл, мэдээллийг нийтэд хүргэх, холбогдох төрийн байгууллагатай мэдээлэл солилцох хэлбэрээр ашиглана.

14.4.Энэ хуульд заасан төрийн байгууллагын эрх бүхий субъект нь хаягжуулах болон түүнтэй холбоотой үйл ажиллагааг зөвхөн хаягийн мэдээллийн системээр дамжуулан зохион байгуулна.

14.5.Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн систем нь геодези, зураг зүйн мэдээллийн сан, газар зохион байгуулалтын төлөвлөлтийн мэдээллийн сан, хот байгуулалтын кадастрын мэдээллийн сан, автозамын мэдээллийн сан, газрын кадастрын мэдээллийн сан, улсын бүртгэлийн мэдээллийн сан, шуудангийн бүсчлэлийн кодын мэдээллийн сан болон төрийн мэдээллийн бусад сантай мэдээлэл солилцох боломжтой байх бөгөөд төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагад дундын мэдээллийн сан үүсгэн ажиллуулна.

14.6.Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн систем нь дундын мэдээллийн сангаар дамжуулан Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай авто замын бүртгэлийн, Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай шуудангийн нэгдсэн бүсчлэлийн чиглэлээр өдөр тутам мэдээлэл солилцох үйл ажиллагааг хангаж ажиллана.

14.7.Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн систем нь дараах шаардлагыг хангасан байна:

14.7.1.улсын хэмжээнд төлөвлөлт, бүртгэлийн шатнаас эхлэн газар, үл хөдлөх, эд, хөрөнгөнд системээс хаяг олгодог онлайн систем байх;

14.7.2.энэ хуульд заасны дагуу газрын эрх үүсэх, үл хөдлөх эд хөрөнгийг улсын комисс хүлээн авснаар хаягийг кадастрын мэдээллийн системд бүртгэдэг байх;

14.7.3.хаягийн мэдээлэл нь ойлгомжтой, нийтэд хүртээмжтэй, нээлттэй, ил тод, хэрэглэхэд хялбар байх;

14.7.4.иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон төрийн байгууллагууд хаягийн орон зайн болон орон зайн бус мэдээллийг ашиглах боломжтой байх;

14.7.5.хаягийн орон зайн мэдээлэл нь замчлалын шаардлагыг хангасан байх.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

15 дугаар зүйл.Хаягжуулалтын үйл ажиллагааны санхүүжилт

15.1.Хаягийн тэмдгийг байршуулахтай холбоотой зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

15.2.Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигч хаягийн тэмдэг, түүнийг байршуулах зардлыг хариуцна.

15.3.Нэгдсэн журмаар хаягжуулсны дараа шинээр өмчлөх, эзэмших эрх зүйн харилцаа үүссэн тохиолдолд тухайн өмчлөгч, эзэмшигч, ашиглагч этгээд хаягжуулахтай холбоотой зардлыг хариуцна.

15.4.Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, хөгжүүлэх, албан хаагчдыг мэргэшүүлэх сургалттай холбоотой үйл ажиллагааны зардлыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага жил бүр улсын төсөвт тусгана.

15.5.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу засаг захиргааны нэгжийн хил зааг, нэр өөрчлөгдсөн тохиолдолд шаардагдах зардлыг шийдвэр гаргасан эрх бүхий этгээд улс эсхүл орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

15.6.Хөшөө, соёл, дурсгал, аялал жуулчлалын байгууламжийг хаягжуулахтай холбоотой зардлыг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

15.7.Энэ хуулийн 9.5-т заасан нэрэмжит болгох хаягжуулалттай холбоотой зардлыг санал болгосон этгээд хариуцна.

15.8.Төрөөс хаягжуулах ажлыг нэг удаа нэгдсэн журмаар зохион байгуулах бол улсын төсвөөс санхүүжүүлнэ.

16 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

16.1.Энэ хуульд заасан хаягийн тэмдгийг гэмтээсэн, устгасан бол буруутай этгээдээр хохирлыг нөхөн төлүүлж, сэргээн засуулна.

16.2.Энэ хуулийн 12.3, 12.13-д заасан үүргээ биелүүлээгүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага тооцно.

16.3.Энэ хуулийн 12.1-д заасан стандартыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага тооцно.

17 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

19.1.Энэ хуулийг 2023... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ